



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

205 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, нийт 85,000,000.00 (наян таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсвийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг бөлгөсугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132280795
10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 07 -ны өдрийн
дугаар тогтоослын хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНІ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ
ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр, марк | Улсын дугаар | Арлын дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтанд он | Тоо ширхэг | Явсан км гүйлт | Балансын үнэ, хурийтлагдсан элэгдэл | Худалдах доод үнэ (төгрөг) |
|---|---|--------------|-----------------------|------------------------------|------------|----------------|-------------------------------------|--|
| 1 | Суудлын автомашин /Пөёота Ланд круизер-70/ | 00-13 ДОА | JTGEB73J7V 9007589 | 2011/2015 | 1 | 568,100 | 85,000,000.00 | 12,232,500.00 (арван хоёр сая хоёр зуун гучин хоёр мянга таван зуу) |
| | Нийт дун | | | | | | 85,000,000.00 (наян таван сая) | |